



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 08 өдөр

Дугаар A/248

Хэрлэн сум

**Уул уурхай, эрдэс баялгийн салбарын  
уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад  
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар, 2023 оны Хорингурав дугаар хуралдааны “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Уул уурхай, эрдэс баялгийн салбарын хариуцлагатай, ил тод байдлыг хангах, өнөөгийн нөхцөл байдлыг хэлэлцэж, цаашдын бодлого чиглэл, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, орон нутагтай хамтран ажиллах гэрээ, ил тод байдлын тайлан мэдээг дүгнэх зорилгоор зохион байгуулж уулзалт, хэлэлцүүлэгт 6,850,000 (зургаан сая найман зуун тавин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010642

Аймгийн Засаг даргын 2024 оны  
А/248 дугаар сарын 08-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Зардлын нэр             | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ /₮/ | Нийт үнэ /₮/ |
|---|-------------------------|-------------|------------|-----------------|--------------|
| 1 | Танхимын түрээс         | Цаг         | 4 цаг      | 800,000         | 3,000,000    |
| 2 | Цайны завсарлага /багц/ | ш           | 140        | 17,500          | 2,450,000    |
| 3 | Талархал хэвлүүлэх      | ш           | 40         | 35,000          | 1,400,000    |
|   |                         |             |            |                 |              |
|   |                         |             |            |                 |              |
|   | Бүгд                    |             |            | 6,850,000       |              |